

ХЯТАДЫН ШАШИН ШҮТЛЭГ ХИИГЭЭД

КҮНЗИЙН СУРТАЛ

С.ЯНЖИНСҮРЭН

МУИС, НШУС, Шашин судлалын тэнхим

Түлхүүр үг: Күнз, даогийн шашин / бумбын шашин/, Инь ян \Yin yan\, Жу жиа \Ju jia\, Мо жиа \Mo jia\, Мин жиа \Ming jia\, Фа жиа \Fa jia\ , Дао дэ жиа \Dao de jia\.

Хятадын шүтлэг бишрэл нь а.т.ө үеэс боловсорч хөгжсөөр өнөөдрийн баялаг түүхийг бүтээсэн байна. Хятадын ард түмний шашин шүтлэг төлөвшиж, хөгжсөн түүхийг дараахь байдлаар ангилж үздэг. Үүнд:

1. А.т.ө I зууны сүүлч - II зууны эхэн хүртэлх үе

Энэ үеийг эртний буюу шилжилтийн үе гэж нэрлэдэг. Учир нь а.т.ө 1000 гаруй жилийн тэртээд хятадын Shang Yin¹ улсын ноёрхол дуусгавар болж, Zhou² улсын үе эхэлснээр хятадын соёлын өнөөгийн дүр төрх хэлбэрших үндэс тавигдсан юм. Тус үед хятадын шашин, гүн ухааны сэтгэлгээний суут төлөөлөгчид болсон Күнз, Мэнз, Жуанз зэрэг олон арван сэтгэгч төрөн гарч, эл үеэс эхлэн Күнзийн сургаалыг сургалтын тогтолцоо болон гүн ухаан сэтгэлгээний суурь дэвсгэр болгон хэрэглэх болов.

2. II - X зуун буюу Sui, Tang улсын үе

Эл үеийг хятадын шашин шүтлэгийн хөгжлийн сонгодог үе гэх ба Күнзийн суртал, Бумбын шашин /Даосизм/, Бурхны шашин гурвын аль аль нь хятадын нийгэмд нэгэнт хэлбэршиж тогтсон үе байлаа. Хятадын соёл Азийн олон улсад, ялангуяа Вьетнам, Солонгос, Японд нэвтэрчээ. Энэ үеэс эхлэн хятадад буддизм өөрийн гэх өвөрмөц дүр төрхтэйгөөр дэлгэрч хөгжсөн бөгөөд тэр нь хятадын иргэншил дэлхийн анхны иргэншлүүдийн нэг мөн байсантай холбоотой.

3. XI- XYIII зууны сүүл үе

¹ А.т.ө 1766-1122 оны үед тогтож байсан хятадын түүхэн дэх хүчирхэг гүрэн. Шан Инь гүрний үед хятадын нийгэмд шашин шүтлэг ихээхэн нөлөөтэй байж, ард түмэн нь далдын хүчинд итгэдэгээр үл барам хүний амьдрал бүтэлтэй, бүтэлгүй байх нь тухайн хүний хувь заяанаас л хамаарна гэж үздэг байв. Тэд мэргэ төлөг буулгадаг байсан бөгөөд хонь, аргалын далаар мэргэлдэг заншилтай байсан байна. Религии мира, Перевод с английского. Белфакс, Москва, 1994. стр 245

² А.т.ө 1122-325 оны хооронд байсан. Чухам энэ гүрний үед л хятадын алдарт сэтгэгчид олноороо төрж гарсан юм.

Тус үеийг хятадын шашин шүтлэгийн дунд үе буюу орчин үеийн өмнөх үе гэж нэрлэнэ. Энэ үед хятадад өрнийн үзэл санааны нөлөө нэвтэрч эхэлсэн байна.

4. XIX – XX зууны үе

XIX зууны үеэс баруун Энэтхэг, Индонез, Малайз, Сингапурын нэгэн адил америкийн колониболлын эдийн засгийн нөлөө аажимдаа хятадын соёл болон шашинд түрэн орох хандлагатай болсон юм.

Дээрх үечлэл бол хятадын уламжлалт шашин шүтлэгт Бумбын шашин, Кунзийн суртал, Бурханы шашин гэсэн 3 шашин зонхилогч байр суурь эзэлдгийг нотолж байна. Тэрбум хол давсан хүн амтай энэ их гүрний ард иргэдийн дийлэнх нь Кунзийн сургаалыг эрхэмлэн хүндэлж, Kong miao гэж нэрлэдэг кунзийн сүм хийдэд өргөл барьц өргөн, залбирал үйлддэгээс үзэхүл, эл суртал Хятадын үндэсний шашины зэрэгт хүрч хөгжсөн байна гэлтэй юм.

Түүний зэрэгцээ Хятадын уламжлалт шашин шүтлэг, гүн ухааны сэтгэлгээнд Даосизмын үзэл баримтлал гүн шингэсэн бөгөөд Dao miao гэх Даогийн сүм хийдэд бас л очдог. Харин а.т.ө 300 оны үеэс хятадын сэтгэлгээнд нэвтрэн орж эхэлсэн гэх бурханы шашины сүм хийд хятадын нутагт олон зуугаараа байдаг. Өдгөө хятадын хүн амын ойролцоогоор 2% нь ислам шашиныг, 1% нь загалмайтны шашиныг шүтэн биширдгээс¹ үзвэл хэдийгээр хятадын төр шашин шүтлэгийг төдийлөн дэмжиж тэтгээд байдаггүй ч, хятад бол шашин шүтлэгийн уламжлалт хэлбэрээ өнөөг хүртэл хадгалсаар ирсэн, олон шашинт улс мөн юм.

Ингэж олон шашин зэрэгцэн оршсоор ирсний шалтгаан нь хятадын хүн ам асар олон бөгөөд хэдэн арван үндэстэн, ястнаас тогтдогтой холбоотой. Хятадын хүн амын 92% нь хань \Han\ үндэстэн байдаг ба түүнээс гадна хасаг, уйгур, монгол, төвд зэрэг томоохон ястнууд буй нь дээр хэлсэнчилэн өөр өөр шашиныг шүтэх нэгэн нөхцөл болдог байна.

А.т.ө YI зуунаас хятадад үүссэн кунзийн сургаал, хятадын гүн ухаан, шашин, ёс зүйн сэтгэлгээнд ихээхэн нөлөө үзүүлснээр өнөөг хүртэл нийгэм-зан суртахууны дэвшилтэт хэм хэмжээ бүрийг түүнтэй холбож ойлгодог болсон байна.

¹ The World book encyclopedia, vol. C-Ch, 3, USA, 1997, p. 476.

Күнзийн сургаалыг күнзийн шашин гэж үзэх нь буй ч, шашин гэхээсээ илүү нийгэм-улс төр, ёс зүйн сургаалын шинж нь давамгайлдаг. Гагцхүү күнзийн сүм хийд, судар ном байдаг гэдгээр л үндэслэн шашин гэвэл ташаа болох юм. Күнзийн сургаал номлолын гол агуулга нь ямар нэгэн чинагуухи далдын хүчнээс аврал өршөөл, энэрэл хайр хүсэхээсээ өмнө, хаан хүн, харц ард, багш, шавь, эр эм, ер хүн бүрийн нийгэмд биеэ авч явах хэм хэмжээг заан сургасан байдаг. Тэрчлэн төрийн удирдлага, сайн, муу төрийн тухай өгүүлсэн нь олон.

Тус сургаалыг өнөөдөр дэлхий дахинд Confucianism хэмээх нэр томъёогоор тэмдэглэдэг. Үндэслэгч нь хятадын их сэтгэгч, мэргэн багш гэж алдаршсан Күнз \Kong zi\ болой.

Тэр бээр а.т.ө ҮI зуун буюу 551 онд хятадын Лу улс \Lu\, одоогоор бол өмнөд хятадын Шань дунь мужийн Цуй фу хотод төржээ. Эцэг Шу Лиэн Хэ \Shu Lian He\ нь нэн зоригт дайчин, үнэнч шударга бөгөөд биерхэг, сайхан эр байсан гэж хятадын ард түмний дунд домогшин үлджээ.

Эхнэр авч олон жил амьдарсан ч гэргий нь 9 охин төрүүлсэн тул удам залгах хүүтэй болох хүсэлдээ хөтлөгдөн бараг 60 хүрсэн хойноо 2 дахь эхнэрээ авсан гэдэг. Удаахь эхнэрээс нь доголлон хөлтэй хүү төрсөнд дахин Янь овогт, өндөр ёс суртахуунтай, хүмүүжилтэй гэр бүлээс гарал бүхий Жэнь Зай гэх 16 настай залуу бүсгүйтэй гэрлэж, хүү төрүүлсэн нь хятадын мэргэн Күнз байжээ. Эцэг Шу Лиэн Хэ нь түүнийг хоёр настайд нас нөгчсөн тул Күнз бээр эхийн хайр халамжид өсөж хүмүүжсэн гэдэг.¹

Түүний ертөнцийг үзэх үзэл бүрэлдэн тогтоход ээж нь ихээхэн нөлөөлсөн гэх бөгөөд эх Жэнь Зай эцгийн нь урдахь хоёр эхнэрээс холдон нүүж, биеэ даан Күнзийг өсгөхдөө өдөр бүр үлгэр, домог ярьж, хятад ардын аман зохиолын гуу сантай танилцуулсан явдал Күнзийн ёс зүйн сэтгэлгээ төлөвших оюун санааны нөхцлийг бүрдүүлсэн байна. Тухайн үед хятад хөвгүүдийг 7, 8 наснаас сургуульд хамруулдаг байсан тул Күнз ч тэр ёсоор сургуульд элсчээ.

Күнзийн анхны багш Янь овогт бээр тухайн үедээ өндөр боловсрол, соёлтой, ёс суртахуунтай хүн байсан нь түүний нийгэм улс төр, ёс зүйн сэтгэлгээ төлөвшиж, хөгжихөд хүчтэй нөлөөлжээ. Янь багш Күнзийг ёс зүйн хэм хэмжээнд сургаж, өөрөө багадаа эцэг эхийн үгийг сонсдог, биелүүлдэг, тэдний зөвшөөрөлгүйгээр гадагш гарч нааддаггүй байсан тухайгаа үлгэрлэн

¹ Конфуций. Минск. 1998. стр. 196-210

хэлж сургахын зэрэгцээ томчуудын яриаг үл таслах, тэдний үгийг үл эсэргүүцэх, тэдэнтэй ярьж байхдаа биеэ шулуун цэх авч явах тэргүүтнийг зааж сургасан гэдэг.

Ингэж залуу Күнз өөрийн эх болон багшийнхаа дэмжлэгтэйгээр нийгмийн язгууртаны зан суртахуунд суралцсан бөгөөд 15-16 наснаасаа үзэл сургаалаа боловсруулсаар хожим хятадын их багш болжээ. Күнз хятадын анхны хувиараа, гэхдээ үнэ ацаггүй хичээл заадаг багш байсан юм.

Түүний шавь нарын тоог хэдэн мянга гэдэг бөгөөд тэдний дотроос чамгүй олон нэрт сэтгэгч төрөн гарсны дотор дэлхий дахинаа алдаршсан Мэнз томоохон байр суурийг эзэлнэ. Күнз бүх хятадаар аялан сургаал номоо дэлгэрүүлсэн байна.

Күнзийн үзэл номлол нь Лиу И буюу "Зургаан жаяг" гэх зургаан зохиол, үүнд, "Мэргэ төлгийн судар" И жин \Yi jing\ буюу "Хувирлын судар", Шу жин \Shu jing\ буюу эртний түүхийн "Баримт бичгийн судар", Ши жин \Shi jing\ буюу эртний хятадын "Яруу найргийн судар", Ли жи \Li zhi\ буюу "Мөргөл ёслолын тэмдэглэл", Чунь чию \Qun qiu\ буюу "Хавар, намар" гэх мэт а.т.ө 720-480 оны хооронд болсон түүхэн үйл явдлуудын эмхтгэл, угийн бичиг, бидний үед хүрч ирээгүй Юйэ жин \Yue jing\ буюу "Хөгжмийн судар" гэсэн хятадын гүн ухаан, төрт ёс, ёс зүй, урлаг, гоо зүйн сэтгэлгээний сонгодог бүтээлүүдэд хадгалагдаж үлдсэн гэдэг. Эдгээр судрыг Күнз зохиосон гэх нь байдаг ч, хэрэг дээрээ хойч үеийнхэн, шавь нар нь, эсвэл Күнзийн сургаал номлолыг даган бишрэгчид түүний үзэл сургаалыг эмхэтгэж гаргасан гэж үзэх нь бас буй. Эдгээрээс сүүлийнх нь өдгөө хүрч ирээгүй тул Вү цин \wu tsing\ буюу "Таван ном" гэж нэрлэх явдал ч байдаг.

Түүнчлэн "...Күнз "Хавар, намрын тэмдэглэлийг" зохиож, "Хувирлын судрыг" тайлбарлаж, "Мөргөл ёслолын тэмдэглэл" ба "Хөгжмийн судрыг" өөрчилж, "Баримт бичгийн судар" болон "Дууллын судрыг" хянан тохиолдуулсан" юм гэж үздэг тал ч буй.¹ Ямартай ч эдгээр бүтээлд Күнзийн үзэл сургаал нэвт тусгагдаж орсны дээр, бүгдэд нь биш юм гэхэд заримд нь тэр бээр биечлэн оролцож бүтээснийг үгүйсгэх аргагүй. Түүнчлэн Күнзийн хүмүүжил хятадын язгууртан иргэдийнх байсан учир дуу хөгжим, яруу найргийн боловсролыг үнэ цэнэтэйд тооцож, энэ талаар бүтээл туурвисан бөгөөд урлагийг хөгжүүлэх нь нийгмийн хөгжлийн нэг гол түлхүүр гэж үзэж байсан байна.

¹ Фен Ю Лань, *Хятадын философийн товч түүх*. УБ, 2003. 44 дэх тал

Күнзийн үзэл сургаалын өөр бусад чухаг эх сурвалжууд гэвэл Сы шу \si shu\ буюу "Дөрвөн ном" гэж хятад даяар алдаршсан "Да сүэ" \Da xue\ буюу "Их суртал" гэх хүн өөрөө өөрийгөө боловсруулах сургаал, Жун юн \Zhong yun\ буюу "Дундадын ном" гэх аливаад хоёр хязгаараас зайлсхийн, төв дундыг барих ёс зүйг сургасан сургаал, хожим шавь нар нь эмхэтгэж гаргасан Лунь юй \Lun yu\ гэх Күнз шавь нартайгаа харилцан ярьж, сурган соёрхсон сургаал, Мэнз \Meng zi\ гэх Күнзийг залгамжлагч, түүний хамгийн мэргэн шавь нарын нэг Мэнзийн сургаал, эдгээр болно.

Күнзийн үзэл сургаалын агуулгыг тодруулан өгүүлэхийн өмнө эхлээд хятадын философич Фен Ю Лань хятадын гүн ухааны түүхийг хэрхэн үечилснийг авч үзсү. Хятадын ард түмний гүн ухааны баялаг сэтгэлгээнээс олон арван урсгал чиглэл үүсч гарсныг эртний хятадын түүхч Сыма Тиан 6 үндсэн сургуульд ялгасан тухай Фен Ю Лань дараахь байдлаар гаргажээ. Үүнд:

1. Ин янг жиа \Yin yang jia\ буюу байгалийн философичдын дэг сургууль. Тэд юм үзэгдэл нэг бүрийн дотоодод эсрэг тэсрэгийн нэгдэл байна гэж үзэж, тэр нэгдлээс бүх ертөнцийн эх үүслийг гаргаж тайлбарлана. Нөгөө талаар энэ дэгийг арга билгийн сургаалтнууд гэж болох юм. Ерөөсөө дорно дахинд арга, билиг гэх хос категорийг ин янг гэж тэмдэглэдэг бөгөөд ин нь эм, янг нь эр эхлэлийг тус тус төлөөлдөг. Ханзын утга нь сар, нарыг заана.

2. Жу жиа \Ju jia\ буюу эрдэмтэний дэг сургууль. Энэ жу нь эрдэмтэй хүн гэх утгатай ханз, өрнөдөд бол күнзийн дэг гэж нэрлэдэг. Энэ дэг үүссэн тэр үед хятадад олон их сэтгэгч төрж гарсан юм.

3. Мо жиа \Mo jia\ буюу моист дэг сургууль. Эртний хятадын нэрт философич Мо цыгийн үзэлд суурилсан эл чиглэлийн гол үзэл санаа нь хатуу чанга сахилга, дэг журмын үзэл санаа болох хийгээд харин күнзийн сурталд заасанчлан хүн ёс, дэг жаяг нэг бүрийг гүйцэтгэж, ёслол бүрийг алдаагүй хийнэ гэвэл хүний нас ч хүрэхгүй, ерөөсөө тийм байх бололцоогүй гэж үзсэн болно. Нэг үгээр хэлэхүл, Мо цы Күнзийг тууштай няцааж, ард түмнийг "хувь заяа" гэдгээр толгойг нь эргүүлж, идэвхигүй байдалд оруулдаг гэж шүүмжилсэн байна. Мо цыгийн дэг сургуультаан нь эрх мэдлээ алдсан цэргийн эрхтэнүүдээс голчлон бүрдэж байсан бөгөөд Күнзийн эрдэмтэний дэг хятадын нийгмийн дээд, дунд давхаргаас бүрдэж басан бол Мо згийн дэг нь доод давхаргаас гаралтай гэж үздэг. Тиймээс ч тэдний гарал үүслийн

ялгаанаас болсон уу, ямартай ч Күнзийн эрхэмлэн үздэг хөгжим, яруу найраг болоод шатлан захирагдах хатуу чанд ёсыг няцааж байсан юм.

4. Мин жиа \Ming jia\ буюу нэрийн дэг сургуультаан. Эл чиглэлийнхэн нэр ба баримт гэгчид ихээхэн ач холбогдол өгч байв.

5. Фа жиа \Fa jia\ буюу хуульчдын дэг. Эл сургуультаан бүх юм, үзэгдэл өөрийн хуультай байна, хүн, нийгэм, төрийг хууль л удирдана, тиймийн тул хуулийг зөв тогтоох нь чухал гэж үзэж байв. Тус дэг философийн түүхэнд легизм гэх нэрээр үлдсэн юм.

6. Дао дэ жиа \Dao de jia\ буюу хятадын их сэтгэгч Лао зы үндэслэсэн дэг. Лаогийн туурвисан "Дао дэ цзин" гэх алдарт зохиолын агуулгыг гол үзэл баримтлалаа болгоно. Тэнд өгүүлэхээр Дао бол бүхний анхдагч эхлэл юм.

Энэхүү ялгал бол Күнзийн сургаал хийгээд Даосын сургаал хятадын ард түмний хувьд сэтгэлгээний үнэт баялаг, ертөнцийг үзэх үзэл, улмаар шашны итгэл бишрэлд ихээхэн нөлөөтэй болохыг нотолж байна.

Күнз тэнгэрийг шүтдэг байжээ. Түүний үзэл сургаалын гол ойлголт нь бүхнийг бүтээгч, чадагч, шийдвэрлэгч тэнгэр бөгөөд тэнгэрийн хүсэл зоригоос бүх юм, үзэгдэл хамаарна, хаан бол тэнгэрийн элч мөн гэж сургадаг байна. Тиймийн тул хааны зарлиг бол тэнгэрийн элчийн зарлиг, цаашилбал тэнгэрийн зарлиг болох юм. Нэгэнт тэнгэрийн хүсэл зориг бүхнийг тодорхойлох тул түүний зарлигийг биелүүлж, даган бишрэх нь чухал гэдэг байна.

Эхэн үедээ тэнгэр гэдэг ойлголт байгалийн тэнгэртэй хамт нэг байгаад, харин тун ухаан, шашны сэтгэлгээ эрс эрчимжсэн Жоу улсын үеэс тэр нь эмпирик тэнгэрээс салж, гагцхүү хүн амьтны амьдрал, амь насыг аварч, тавархын хэрхэхийг хэний ч оролцоогүйгээр шийдвэрлэдэг тийм дээд, чинагуух хүчний ойлголт болсон бололтой. Тэгээд ч тэнгэрийг бас бүхний анхдагч эхлэл хэмээн үзэх болжээ.

Күнзийнхээр хүний танин мэдэхүйн хэмжүүр ч тэнгэр байсан юм. Тэнгэрийн хүсэл зоригийг танин мэдээгүй хүнийг мунхаг, харанхуйд тооцож байв. Тэрбээр өвөг дээдэс, өмнөх үе, ахмадуудаа шүтэн биширдэг байсан тул шавь нараа ч өвөг дээдсийн сургаал номлолыг даган бишрэх, хүндэтгэх, сурж судлахыг уриалж байлаа. Күнз бээр өөрийгөө эртний сэтгэгчид, хаад ноёдын сургаалыг хойч үед дамжуулж хэлдэг болохоос биш, өөрөө

санаанаасаа зохиосон, хиймэл зүйл байхгүй гэж үздэг нь Лунь юид өгүүлсэнчлэн тэр "бүтээдэггүй, дамжуулдаг"¹ байснаар илэрдэг байна.

Күнз хүнийг идэвхитэй амьдралд уриалан дуудагч байсан юм. Мэдлэг эзэмших гол арга зам нь хүн өөрөө хичээж, чармайх явдал мөн гэж үзэж байлаа. Тиймийн тул өнөө хийхийг маргааш гэж үл хойшлуулваас сая зорилгодоо хүрнэ, маргаашийн ажил гэж бас буй гэжээ. Ер нь Күнзийн үзэл сургаалыг мэдлэгийн тухай сургаал, хүний тухай сургаал, ёс суртахууны тухай сургаал гэж ялган авч үзэж болох бөгөөд тэдгээрийн дотроос хүний тухай сургаал нь зонхилогч байрыг эзэлдэг байна.

Тэрбээр хүн, хүний нийгэм, төр, төрийн сайн удирдлагын тухай сургасан нь ихэнх юм. Хүн тэнгэрийн бүтээл мөн бөгөөд хүний мөн чанар нь хүнлэг энэрэнгүй чанар, шударга ёс хоёр мөн гэж үзжээ. Хүн хүнлэг байхын тулд өөрийнхөө хийхийг үл хүсэх тийм зүйлийг бусдаар үл хийлгэх, өөрийгөө төгөлдөржүүлэхийг хүсэхдээ бусдыг бас төгөлдөржүүлэх, өөрийгөө хайрлуулахыг хүсвэл бусдыг хайрлах, өөрийгөө хүндлүүлэхийг хүсвэл бусдыг хүндлэх ёстой. Энэ нь хүнлэг энэрэнгүй ёсны гол шалгуур мөн гэж үзэж байжээ. Хүнлэг байхын үндэс нь хайр, бусдыг хайрлаж чаддаг байх явдал мөн гэж үзжээ.

Күнзийн ёс зүйн сургаалд дараахи хэдэн ойлголт чухал үүрэгтэй юм. Үүнд: И \I\ буюу шударга ёс, Ли \Li\ буюу ашиг олз, Жэнь \Jian\ буюу хүнлэг ёс, Жүн \Jung\ буюу үнэнч байдал, Шү \Shu\ буюу шударга бус, Мин \ming\ буюу зүй тогтол, эдгээр болно. Түүний үзлээр ариун хүн шударга байдаг, адаг доорд хүн олз ашиг хайдаг гэх ба шударга хүн өөрийн тухайд хүсээгүйг бусдын тухайд үйлддэггүй гэдэг. Бүхэлдээ хүнлэг байхын утга нь шударга байдлыг өөртөө бий болгож, шударга бус чанараас ангижирах явдал мөн гэжээ. Бас хүнлэг, төгс төгөлдөр, сайн хүн байхад саад тотгор болдог ёс зүйн сөрөг хэм хэмжээнүүдийг ч тодорхойлсон байна. Үүнд, хүнийг муу хэлэх, гүжирдэх, шийдэмгий боловч бодлогогүй хөдлөх, зоригтой боловч ёс горимыг үл сахих зэрэг болно. Хүн хүнлэг байхын тулд өсөх насанд цэнгэлийг, идэр насанд тэмцлийг, өтөл насанд шуналыг тэвчих явдал нэн чухал гээд хүнлэг энэрэнгүй байдал бол хүнээс тийм их алс хол байдаг, түүнийг өөртөө дадуулахын тухайд их хүч зарах зүйл биш, харин хүнтэй өөртэй нь хамт төрдөг төрөлх зүйл, тэр бол хайр юм. Хүн хүнээ хайрлах нь хүнлэг ёсны энгийн илрэл. Тиймийн тул бусдыг эцэг, эх мэт хайрлаж,

¹ Фен Ю Лань, *Хятадын философийн товч түүх*. УБ, 2003 44-45 дахь талууд

зөвэрүү зөөлөн харилцаж, үнэнч шударгыг эрхэмлэж, зовлонг туулах тэсвэртэй байж гэмээнэ бусдыг өөр шигээ хайрлаж чадна гэж сургасан байна.

Күнзийн сургаалд нэвт шувт шингэсэн байдаг нэг гол зарчим нь хүний үүрэг хариуцлага буюу И¹ юм. Аливаа ажил хэрэг самуурч, бүтэлгүйтэх нь хүн үүрэг хариуцлагаа умартсанаас болдог. Эртний хаадын үеийн төр сайн байсны учир нь тэд үүрэг хариуцлагаа гүнээ ухамсарладаг, ягштал дагаж биелүүлдэг байсантай л холбоотой. Одоо төр сул дорой байгаа нь хаад үүрэг хариуцлагаа биелүүлэхгүй байгаатай л холбоотой гэж үзэж байсан нь тэрбээр уламжлалыг баримтлагч, дэмжигч байсныг харуулдаг.

Тиймээс ч күнзийн сурталтнуудын хувьд өвөг дээдэс бол тэдний гол шүтээн, үнэн хийгээд ариун, чигч шударгын бэлгэдэл болдог. Түүний илрэл нь хятадын ихэнх айл гэртээ өвөг дээдсийн сүнс, онгоныг агуулсан миао /miao/ буюу бунхантай байх бөгөөд тэр бунхан гэрийнх нь гадаа байх нь ч буй. Буян үйлдвээс зохих бэлгэт сайн өдрүүдэд эл бунхандаа идээ ундаа өргөж, эд эдлэл, мөнгийг бэлгэдсэн цаасан дуураймал зүйлсийг галд шатаан өргөл үйлдэнэ. Ихэнхдээ дуураймал мөнгийг шатаах бөгөөд хэдий чинээ ихийг шатаана, төдий чинээ их буян үйлдсэнд тооцогдох ба эргээд тэр хэрээр өвөг дээдэс нь ивээж, олз ашиг ихтэй байхын бэлгэдэл болгодог бололтой. Галын утаагаар дамжиж, тэнгэрт буй дээдсийн сүнс сүлдэнд шатаасан эд зүйлс, мөнгө зэрэг нь очино гэж үзнэ. Хэд хэдэн бунхантай байх тохиолдол ч байна. Тухайн хүний зэрэг дэв, нийгэмд эзэлж байсан байр суурь, язгуур угсаанаас хамаараад бунхан нь 1, 3, 5, 7 гэх мэт байна. Язгуур угсаа, зэрэг дэв дээшлэх тусам олон болно. * * * * *

Ингэж өвөг дээдэс, эртний хаадыг шүтэх Күнзийн үзэл өнөө хэр хятадын ард түмний дунд амь бөхтэй оршсоор байгаа юм.

Иймэрхүү бунхануудыг бас газар, уул ус, лус, савдагийн эздэд зориулж байгуулах бөгөөд уул хаданд, эсвэл тариалангийн талбайн дэргэд байх нь элбэг. Түүнийг Ту ди /tu di\ гэх бөгөөд хэлбэр, өнгө үзэмжийн хувьд айлын миаогоос ялгарах зүйл үгүй. Хур борооны үе, ургацын улиралд тэнд очин мөргөл үйлдэж, хүж унгатган байгалийн гамшгийг зайлуулах тухайд уул

¹ Хятад хэлний ханз үсэг бүр нэг утгыг илэрхийлэх бөгөөд харин дуудлагын хувьд 4 ялгарна. Түүнийгээ хөг гэх ба тухайлбал, И гэдэг ханз 1, 2, 3, 4 гэсэн 4 хөгтэй байж аль хөгөөр нь дуудаж буйгаас бичлэг нь өөр байна. Монгол хэлэнд нэгэнт ийм хөг, хөгийг тэмдэглэх үсэг үгүй тул тэр хөгийг илэрхийлэх болмжгүйн зэрэгцээ энд нэгэнт хятадын шашины тухай ярьж байгаа учир жишээлбэл, И гэдэг өөр өөр ханз үсгийг нэгэн байдлаар тэмдэглэхээс аргагүйд хүрэв.

усны шүтээнд ханддаг. Энэ бол Күнзийн суртлын бус, харин өвөг дээдсийг нутаглуулах тансаг ёслолыг эсэргүүцдэг, лус савдагийг хүлээн зөвшөөрдөг моизмын үзэлтэй холбоотой бөгөөд хятадын шашны зан үйлүүд нь шашны төрөл бүрийн хэлбэрийн синтез шинж чанартай болохыг харуулж байгаа юм.

Күнзийн нийгэм-улс төрийн сургаалын үндэс нь эзэн хаанаа хүндэтгэх, хаан төрөө дээдлэх үзлээр илэрнэ. Гэхдээ Күнз бээр зөвхөн хүн ардаас эзэн хаан, хаант төрөө дээдлэн хүндлэх тухайд сургасан бус, харин төрийн эзэн хаан хүн зон олныхоо хайр хүндэтгэлийг хэрхэн татах тухайд сургасан юм. Үүний тулд хаан хүнд үлгэр жишээч байх, ард түмэндээ хүндэтгэлтэй хандах, хүнлэг ёсыг сахин биелүүлэх, олны санаа зоригийг сонсдог байх шаардлага тавьж байв. Ерөөс тэрбээр хаан, ард хоёрын харилцаа нь эцэг, хүү хоёрын харилцаа шиг байж, төрийн эзэн хаан хүн үр хүүхдээ энэрэх эцэг шиг ард олноо хайрлаж, ард олон нь эцгээ асрах хүү мэт эзэн хаандаа хүндэтгэлтэй хандах ёстой. Бат бэх төрийн үндэс үүнд л оршино гэж үзсэн юм. Тэрээр хаан төрийг хууль биш, харин ёс суртахуунлаг зөв үйл л удирдах ёстой гээд үүний дээр шударга ёсыг нэмвээс сая төр нь нэн сайн болж чадна гэж сургажээ. Күнз хаан хүн, харц ардын ёс зүйн тухай сургасан нь цаанаа бол удирдах хийгээд удирдуулах ёсны тухай, улмаар ерөөсөө удирдлагын тухай сургаал байсан юм.

Күнз аливаа зүйлийн нэрэнд их ач холбогдол өгч, нэр буруу бол үг тэрслүү, үг тэрслүү бол үйлс үл бүтэх, үйлс үл бүтвээс ёс заншил хийгээд дуу хөгжим үл цэцэглэх, түүнээс торгууль шийтгэл буруу оногдох, тиймээс хүн ард тайван байх нөхцөлгүй болох тухай сургажээ. Нэр нь утга төгөлдөр байгаад уг зүйл нь өөрөө нэрэндээ дүйж байваас ажил үйл өөдлөхийн бэлэг гэж "нэрийг засах" хэмээх үзлийг бий болгосон байна. Үүнийгээ Күнз, хаан нь хаан шиг, түшмэд нь түшмэл шиг, эцэг нь эцэг шиг, хүү нь хүү шиг байваас зохино хэмээн томёолжээ.

Күнзийн сургаалыг хятад даяар түгэн дэлгэрч, хятадын ард түмний сэтгэлгээнд гүн гүнзгий ул мөрөө үлдээхэд түүний мэргэн шавь Мэнз ихээхэн үүрэг гүйцэтгэсэн байна. Ингэхдээ тэрбээр багшийнхаа сургаалыг тэр чигээр нь хуулбарласангүй, харин ч бүтээлчээр хандахыг эрхэмлэж, тэнгэрийн хүсэл зоригийн үзэл санааг нь шүүмжлэн няцаасан юм.

Хятадын шашин шүтлэг зан үйлийн хувьд баялаг юм. Сүнс байдаг гэж үзээд, бас чөтгөр, шулмын тухай ойлголтыг хүлээн зөвшөөрдөг. Шинэ жилээр, ялангуяа жил орж байгаа хүн заавал улаан өнгийн хувцас өмсөж, эд

эдлэл хэрэглэдэг. Учир нь хятад хэлний жил /nian/ буюу ниан гэдэг үг нь чөтгөр гэдэг үгтэй адил дуудлагатай тул жил орж байгаа хүнд чөтгөр хамгийн ойрхон байдаг гээд, тэр чөтгөр нь улаан өнгөнөөс айх тул ийнхүү улаан өнгийн хувцас өмсөнө. Жил орох үед хүний аз хийморь эмзэг байдаг гэж асан бадрахын утгыг ч давхар илэрхийлнэ.

Ер нь хятадууд ихээхэн цээрч ард түмэн юм. Тэд гэрт шүхэр дэлгэх, хүнд алчуур бэлэглэхийг тэвчдэг. Юй сан /Yu san/, янг сан /Yang san/ гэдгийн сан гэдэг нь шүхэр гэсэн утгатай бөгөөд салах гэдгийн сантай /san/ адил дуудлагатай тул, нас барагсдыг хөдөөлүүлэх ёслол дээр алчуур тараадаг тул, дээрх үйлдлүүдийг тус тус цээрлэдэг байна.

Бас гахай, зоосон мөнгө, юмбүү зэргийг баян, элбэг дэлбэгийн, хаш чулууг ээлтэй сайны бэлгэ тэмдэг болгож, гэр орондоо байлгадаг. Ингэж эд өлгийн зүйлсээр бэлгэдэн үзэж, сайныг урин дуудах, мууг үлдэн хөөх аргыг хятадын шүтлэгт Фэн шүй гэнэ. Эд эдлэлийг дангаар нь бус, орон зай, өнгө, хэлбэрийн шүтэлцээнд оруулаад, тэдгээр нь ямар байдалд байхдаа хүний амьдралд эерэг буюу сөрөг ямар нөлөө үзүүлдэг болохыг тодорхойлохыг оролддог байна. Тэд зүг чиг, өнгө, дүрс, ер нь аливаа юм үзэгдлийг эр, эм хийгээд эерэг, сөрөг хэмээн ялгаж, түүнд нь зохицсон сайн, муу энерги гардаг гээд ямар энерги ялгарна, тэр нь хүний амьдралд шийдвэрлэх нөлөөтэй байдаг гэж энэ шүтлэг номлодог байна. Хятадын ард түмэн "салхи, ус" гэх дээрх шүтлэгийг дагах явдал нэн түгээмэл. Тиймийн тул хятад иргэд чөтгөр, шулмыг хөөхийн утгаар гэрийнхээ хаалганд хонх зүүж, эр зүг гэх баруун, ялангуяа баруун хойд зүгт тод улаан, улаан хүрэн өнгийн эд зүйлс байлгахыг эрхэмлэдэг. Тэрчлэн болор өд эдлэл нарны туяаг нэвтрүүлэхдээ мууг нь шингээн авч үлдээд, сайныг нь түгээдэг гэж гэр орондоо байлгах дуртай. Энэ бүхэн бол хятадын ард түмэн эртнээс нааш байгалийг аж төрөлдөө эерэгээр ашиглахыг оролдсоор ирсний илрэл буюу. Ерөөсөө байгалийг шүтэх үзэл өнөө хэр амь бөхтэй оршсоор байна гэж дүгнэж болох юм.

Тэд хүн нас барсны дараа оюун санаа нь гурван байрлалд үргэлжлэн амьдарсаар байдаг гэж үзнэ. Нэг хэсэг нь тэнгэрт, хоёр дахь хэсэг нь өргөл барьц авахын тухайтад булш шарилд, үлдэх хэсэг нь гэр бүлийн бунханд орших юм. Ялангуяа тэнгэрт одож байгаа сүнс, оюун санаа нь багагүй урт замыг туулна, гэхдээ зовох магадлал өндөртэй гэж өргөл, мөргөл хийхдээ идээ будаа бэлдэхээс гадна өмнө хэлсэн шиг эд, зүйлсийн дүрс, дуураймал

цаасан мөнгө шатаана. Тэр шатааж байгаа зүйлс нь хаа хамаагүй зүйл бус, харин нас нөгчигсдийн амьд ахуйдаа эдэлж хэрэглэж байсан эд хөрөнгийн дүр байдалтай зүйл байдаг.

Хятадын ард түмний шүтлэгийн байдлаас үзэхүл, ёс зүйн сургаалын шинж ч буй, шүтлэгийн маш нарийн тогтолцоо ч буй нь харагддаг. Угаасаа газар нутгийнхаа хувьд байгальтайгаа ойр дотно харьцах боломжоор хангагдсан бөгөөд тэр нь тэдний эрхэлж байгаа зонхилох аж ахуйн хэлбэрээр дамжин илэрч байна гэж хэлж болно. Газар тариаланг эрчимжүүлэхэд хүний өөрийн хүчин зүйлээс гадна байгалийн хүчин зүйл ихээхэн нөлөөтэй. Тиймээс ч хятадын сэтгэлгээний үндэс нь Ин, янг хоёр болжээ гэж үзэж болом ажгуу. Үгийн хувьдаа бол сар, нарыг төлөөлөх энэ хоёр ханзанд байгаль бүхэлдээ багтсан бөгөөд хожим нь харин хослол, шалтгаант холбоо, шүтэн барилдлага гэсэн утгыг илтгэх болсон мэт. Нэг үгээр хэлэхүл, хятад хүний хувьд амьдралд нь байгаль хамгийн их нөлөөтэй байсан юм. Нөгөөтэйгүүр, суурьшмал иргэншилтэй, нэгэн дор олноороо амьдарч байгаа хүн ардад сахилга, дэг журам, ёс суртахуун нэн чухал. Тиймээс ч Хятадын нийгэмд өнөөг хүртэл ёс зүйн асуудал өндөрт тавигдсаар байна. Харин тэрхүү ёс зүйн уламжлалт сэтгэлгээнд нь Күнзийн сургаал зонхилсоор ирсэн болохыг дээр өгүүлсэн билээ.

Ном зүй

1. The World book encyclopedia, vol, C-Ch, 3, USA, 1997. p. 476.,
2. China Review International volume 6. № 2.1999. University of Havai.
3. The Journal of Religion. The University of chigago. 2000.
4. Конфуций. Минск . 1998.
5. С.П . Фицджеральд.
Китай. Краткая история культуры. Санкт Петербург. 1998.
6. Народы и Религии мира. Энциклопедия, Москва, 1999.
7. Религии мира. Перевод с английского, Москва, 1999.
8. Фен Ю лань, Хятадын философийн товч түүх. УБ., 2003.
9. Күнз. Шүүмжлэл өгүүлэл. Орч. М. Чимэдцэеэ. УБ., 2004.

Chinese faith and Confucianism

Key words: Kong zi, Ying yang jia, Ju jia, Mo jia, Min jia, Fa jia, Dao de jia.

Chinese faith has been developing from B. C. A until today, it created rich history. Chinese faith or religions has a following classification.

1. The end of B. C. A I century – beginning of II century
2. II - X century or Sui, Tang dynasty
3. XI - the end of XYIII century
4. XIX – XX century

This classification shows that, Daocism, Confucianism and Buddhism made main roles in Chinese religious development.